



**ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ТУШААЛ**

2010 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/70

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын 2010 оны ТГ/919 албан тоот бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “Өндөр, дээд түвшинд солилцох захидлыг бэлтгэх тухай журам”-ыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Журмыг хэрэгжүүлж ажиллахыг ГХЯ-ны нэгжийн удирдлага, ДТГ-ын тэргүүн нарт, түүний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТЗУГ, ТДЁГ-ын захирал нарт тус даалгасугай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Б.БАЯРСАЙХАН



ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын
2010 оны 1/20 тоот тушаалын хавсралт

ӨНДӨР, ДЭЭД ТҮВШИНД СОЛИЛЦОХ БАЯРЫН ЗАХИДЛЫГ БЭЛТГЭХ ЖУРМЫН ТУХАЙ

Нэг.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Гадаад харилцааны сайд нараас илгээх захидлын төслийг боловсруулах, хянуулах, танилцуулах, ёсчлон бэлтгэх, илгээх зэрэг үйл ажиллагааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.

Хоёр.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Гадаад харилцааны сайд нараас гадаад улсын удирдлагад үндэсний баярыг нь тохиолдуулан илгээх мэндчилгээ захидал, Монгол Улсын үндэсний баяраар гадаад улсын удирдлагаас ирүүлсэн мэндчилгээний хариу захидал, дипломат харилцаа тогтоосны тэгш ойг тохиолдуулан илгээх захидал, аливаа айлчлалын дараа илгээх талархлын захидал болон бусад асуудлаар илгээх захидал энэ журамд хамрагдана.

Гурав.Захидлын төслийг тухайн улс, олон улсын байгууллагатай харилцах асуудлыг хариуцсан газар бэлтгэнэ. Захидлын төслийг боловсруулахдаа тухайн улсад болон олон улсын байгууллагын дэргэд суугаа Дипломат төлөөлөгчийн газрын саналыг заавал авна. Захидлын төслийг боловсруулахдаа тухайн асуудлаар өмнөх жилүүдэд солилцсон захидлуудын агуулга, харилцааны сүүлийн үеийн өрнөл, үйл явдлыг шинжлэн дүгнэж тусгана.

Дөрөв.Захидлын хэлбэрийг харилцан адил байх зарчмыг баримтлан сонгоно. Өргөн харилцаагүй улсад илгээх захидлыг болон нөгөө талаас гарын үсэггүй захидал ирдэг тохиолдолд манай талаас илгээх захидлыг гарын үсэг зуруулахгүй цахилгаан утас хэлбэрээр илгээнэ. Ийм захидлын төслийг дээд удирдлагад заавал танилцуулна.

Дөрөв.Захидлын төслийг тухайн улс, олон улсын байгууллагатай харилцах асуудлыг хариуцсан газар Гадаад харилцааны яамны удирдлагад танилцуулж эцэслэнэ.

Тав.Захидлын орчуулгыг тухайн улсын хэлээр, боломжгүй тохиолдолд НҮБ-ын албан ёсны аль нэг хэл дээр хийнэ. Захидлын орчуулгыг тухайн улс, олон улсын байгууллагатай харилцах асуудлыг хариуцсан газар хийж гүйцэтгэнэ.

Зургаа.Гадаад харилцааны яамны түвшинд эцэслэн боловсруулсан захидлын төслийг уг үйл явдал тохиох өдрөөс 14 хоногийн өмнө Ерөнхийлөгчийн Тамгын газар, УИХ-ын Тамгын газар, Ерөнхий сайдын ажлын албанд тус тус хүргүүлнэ. Захидлын төслийн хамт өмнөх жил тухайн асуудлаар солилцсон захидлуудын хуулбарыг хамт хүргүүлнэ.

Долоо.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд нар танилцаж, эцэслэсэн төслийг захидлын албан ёсны хэвлэмэл хуудас дээр бичих, гарын үсэг зуруулах асуудлыг Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд нарын гадаад бодлогын асуудал эрхэлсэн зөвлөхүүд тус тус хариуцан гүйцэтгүүлнэ.

Найм.Захидлын эх хувийг дипломат шугамаар айлын талд уламжлах асуудлыг ГХЯ-ны холбогдох газрууд хариуцана. Чингэхдээ тухайн улс, олон улсын байгууллагын дэргэд суугаа ДТГ-т цахим хэлбэрээр шуурхай дамжуулж, эх хувийг дипломат шуудангаар хүргүүлнэ. Захидлын хуулбарыг тухайн улсаас Монгол Улсад суугаа ДТГ-т ноот бичиг дагалдуулан гардуулна.

Ес.Монгол Улсаас тухайн улс, олон улсын байгууллагын дэргэд суугаа ДТГ хүлээн авсан захидлыг суугаа орны холбогдох байгууллагад шуурхай уламжилна. Захидлыг ДТГ-ын ноот дагалдуулан гардуулна. Захидлыг гардуулсан тухайгаа тухайн ДТГ ГХЯ-ны холбогдох газарт хариу илтгэнэ.

Арав.Захидал илгээсэн тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлж болно. ГХЯ-ны Хэвлэл, мэдээлэл, олон нийттэй харилцах газар захидлыг бэлтгэн илгээсэн газартай хамтран энэ асуудлыг гүйцэтгэнэ.

Арван нэг. Захидлын нэг эх хувийг холбогдох хэрэгт авч үлдэнэ.

Арван хоёр. Монгол Улстай дипломат харилцаатай улс орнуудын үндэсний баярын өдөр, тухайн жил дипломат харилцааны тэгш ой тохиох орнуудын жагсаалтыг Төрийн дипломат ёслолын газар өмнөх жилийнх нь дөрөвдүгээр улиралд гаргаж, холбогдох газарт мэдээлнэ. Түүнчлэн тухайн сард үндэсний баяр нь тохиох орнуудын жагсаалтыг өмнөх сарынх нь эхний долоо хоногт багтаан гаргаж, холбогдох газарт нь мэдээлнэ.

Арван гурав. ГХЯ-ны бүх газар, хэлтэс, ДТГ-ууд энэ журмыг чанд мөрдөж ажиллана.

Арван дөрөв.ГХЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газар, Төрийн дипломат ёслолын газар энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана. Энэ журмын хэрэгжилтийг улирал тутамд яамны удирдлагад илтгэнэ.